



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг хавсралтын ёсоор баталсугай.
- 2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Импортын барааны гаалийн албан татварын тухай" Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 24, "Импортын зарим бараанд гаалийн албан татвар тогтоох тухай" 1998 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
- 3.Энэ тогтоолыг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 4.Энэ тогтоолын хавсралтын 02, 04, 07, 08, 16, 19, 20, 21, 22 дугаар бүлгийн 22.01, 22.02, 22.09 дэх зүйл, 25, 26, 27, ~~27~~, 35, 39, 40, 41, 42, 43, 44, 48, 49, 51, 56, 57, 61, 62, 63, 64, 68, 69, 70, 87, 94 дүгээр бүлэгт заасан хязгаарт багтаан холбогдох барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тухайн салбарын бүтээгдэхүүний онцлогийг харгалзан тогтоох эрхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т олгосугай.

[/Энэ заалтад "26. " гэсний дараа "27. " гэж 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 12 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө./](#)

[/Энэ заалтад "26. " гэсний дараа "27. " гэж 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 88 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан бөгөөд 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө./](#)

[/Энэ заалтыг 2012 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 27 дугаар тогтоолоор нэмсэн, 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан, энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 17 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./](#)

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

/Энэ тогтоолын хавсралтад 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 51 дүгээр тогтоол, 2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр тогтоол, 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 44 дүгээр тогтоол, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 43 дугаар тогтоол, 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 26 дугаар тогтоол, 2011 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 19 дүгээр тогтоол, 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 40 дүгээр тогтоол, 2013 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 44 дүгээр тогтоол, 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 74 дүгээр тогтоол, 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 17 дугаар тогтоолоор тус тус орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгав/